



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2014 оны 01 сарын 09 өдөр

Дугаар A/01

Улаанбаатар хот

Зочид буудал, дэн буудлын газрын
үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох тухай

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам"-ын 5.1 дэх хэсэг, Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрмийн 2.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Аялал жуулчлал, дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS5738:2007" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын хавсралтаар баталсан иргэн, аж ахуйн нэгжүүдэд дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгосугай.

2. Энэхүү тушаалыг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Нийслэлийн Цагдаагийн газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг үйлчилгээний байгууллага хариуцсан мэргэжилтэн /С.Туул/-д үүрэг болгосугай.

3. Тушаалын үнэт цаасны бичилт, олголтод байнгын хяналт тавьж ажиллахыг ахлах нягтлан бодогч /П.Ариунаа/-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Э.БАТТУЛГА

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2014 оны 01 сарын 09-ны өдрийн
А/01 тоот тушаалын хавсралт



ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА
ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ИРГЭН, АЖ АХУЙН
НЭГЖҮҮДИЙН ЖАГСААЛТ

2014.01.09

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, Аж ахуйн нэгжийн нэр	Оноосон нэр	Байршил
1	Иргэн С.Гантөмөр	Сан-Му	Баянгол дүүрэг, 8-р хороо, Жамсранжавын гудамж 14
2	Монгол цонх групп ХХК	Цонх	Баянгол дүүрэг, 3-р хороо, Замчдын гудамж 6/1
3	Цоглог хангай ХХК	Очир титэм	Баянгол дүүрэг, 7-р хороо, Баруун Ард Аюуш
4	Иргэн Д.Батсайхан	Аппле	Баянгол дүүрэг, 11-р хороо, Баруун Ард Аюушийн 1/АОС 7

-ooOoo-